

Дундговь аймаг дахь  
Төрийн аудитын газар



**“АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР  
НӨЛӨӨ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” ЖИЛИЙН  
ХҮРЭЭНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**“ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ҮР ДҮН”-Д ХИЙСЭН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудитор  
Р.Мөнхтогтох Утас: 70592439,

Аудитын менежер Х.Наранцацрал  
Утас: 70592225

Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Аудитор Ж.Угтахбаяр

Утас: 7059-3113,

Цахим хаяг: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим  
хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	2
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3-4
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<b>БҮЛЭГ 1.</b> Аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажлууд үр дүнд хүрч, 1 санал нэгтгэсэн тайланд тусгагдсан байна.	
Аудитын менежер Х.Наранцацрал	<b>1.1</b> Аудитаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалттай байна.	5-10
Аудитор Т.Оюун-Эрдэнэ	<b>1.2</b> Аудитын үр дүнд хуульд заасны дагуу шаардлагатай зардлын төсвийг батлуулж байх тухай санал нэгтгэсэн тайланд орсон байна.	10-11
Аудитор Ж.Угтахбаяр	<b>БҮЛЭГ 2.</b> Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулжээ.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	<b>2.1</b> Гүйцэтгэлийн аудитын дүнд боловсролын байгууллагуудын талаар баримтлах бодлого сайжирч, шаардлагатай арга, хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна .	11-12
<b>ХАЯГ:</b>	Дүгнэлт	13-14
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	Зөвлөмж	14
2023 оны 11 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

<b>МУЕА</b>	Монгол Улсын Ерөнхий аудитор
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>ТАБ</b>	Төрийн аудитын байгууллага
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>ХБТХОХ</b>	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
<b>ГИЦС</b>	Говийн Ирээдүй цогцолбор сургууль
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>БҮТ</b>	Боловсролын үнэлгээний төв
<b>ЭДЦС</b>	Эрдмийн далай цогцолбор сургууль
<b>МУБИС</b>	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>УТХО</b>	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
<b>ХШҮХ</b>	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэн эрх:*

Аудитыг МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.3, МУЕА-ын 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу өөрийн санаачилгаар хийлээ.

*Аудитын зорилт:*

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд **“Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал үр дүн”**-д хийсэн аудитын үр дүнд өгсөн зөвлөмж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн саналын хэрэгжилтийг ирүүлсэн хариу тайлбар, нотлох баримттай газар дээр нь тулган шалгах, үр дүнг тооцож зорилтын биелэлтийг хангах, аудитын үр дүнг тайлагнахад чиглэнэ.

*Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:*

Хяналт шалгалтад илрүүлэлтийн хүснэгтэд тусгасан асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах стандарт, хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ❖ АДБОУС
- ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020
- ❖ МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам
- ❖ МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан ГА-ын заавар, аргачлал /5.8/

*Аудитын хамарсан хүрээ:*

Аудитад Дундговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар, сумдын Ерөнхий боловсролын сургуулиуд болон бусад холбогдох байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулсан.

Шалгалтыг аудитын матрицад тусгасан асуулт, арга зүй, нотлох баримт цуглуулах аргуудын хүрээнд хийж, нөхцөл байдал, үр дүнг аудитын илрүүлэлтийн хүснэгтээр баримтжуулсан.

*Аудитын арга зүй:*

Шалгалтыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг

*Аудит хийх багийн  
бүрэлдэхүүн, хугацаа:*

ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, шалгалтын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Т.Оюун-Эрдэнэ, аудитор Ж.Угтахбаяр нар 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

*Аудитын дүн*

Аудитаар аймгийн Засаг даргад Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасны дагуу “Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан батлуулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүлээ.



## **БҮЛЭГ 1. Аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажлууд үр дүнд хүрч, хуульд заасны дагуу шаардлагатай зардлын төсвийг батлуулах тухай санал нэгтгэсэн тайланд орсон байна.**

### **1.1 Аудитаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалттай байна.**

*Зөвлөмж №1-ийн хүрээнд<sup>1</sup>:*

Аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/1681 дугаар албан бичгээр ирүүлжээ.

Албан бичигт “*Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, өнөөгийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад бодлогын баримтад нийцсэн бодлогыг тодорхойлон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн стратеги төлөвлөгөөнд 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.*” гэж зөвлөмжийн хариу ирүүлсэн байна.

Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, өнөөгийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад бодлогын баримтад нийцсэн бодлогыг тодорхойлсон гэх боловч ажлын тайлан, нотлох баримтууд байхгүй байлаа.

Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд боловсролын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилго, 3 зорилт, 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас ЕБС-ийн үйл ажиллагаатай холбоотой 1 зорилт, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр;

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т боловсролын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилго, 3 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас ЕБС-ийн үйл ажиллагаатай холбоотой 1 зорилт, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Мөн зөвлөмжийн хариуд “*Бодлогын баримт бичгүүдийн тухай жилд гүйцэтгэх ажлуудыг Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хэрэгжилтийг тооцож ажилласнаар бодит үр дүнг гаргаж байна*” гэжээ.

---

<sup>1</sup> *Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, өнөөгийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад бодлогын баримт бичигт нийцсэн бодлого боловсруулж ажиллах.*

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгүүдийн тухайн жилд гүйцэтгэх ажлуудыг тусган хэрэгжүүлж, 2021 онд 91.3 хувь, 2022 онд 92.0 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.

**Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллажээ.**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардлыг арилгах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай 2015 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байна.

Аудитаар Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т */Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих/* заасны дагуу боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлах тухай зөвлөмжийг Аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2023 оны 07 дугаар сард Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэн ба тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т дээрх заалтыг дахин хуульчилсан тул “Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан батлуулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүлээ.

*Зөвлөмж №2-ын хүрээнд<sup>2</sup>:*

Зөвлөмжийн хүрээнд боловсролын салбарт 2022-2025 онуудад хийгдэх төсөл арга хэмжээ болон зураг төсөв нь бэлэн байгаа барилга, байгууламж, дэд бүтцийн угсралт, засварын ажлын судалгааг нэгтгэн ХБТХОХ-т хүргүүлснээр үе шаттай хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэх боломжтой болсон байна.

**Хүүхдүүдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг сайжруулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 сургуулийн хичээлийн байр, 2 сургуулийн дотуур байрны барилгын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авчээ.**

2020 оны байдлаар Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн барилгын чанар, төлөв байдлын дүгнэлт */Барилга байгууламжид тавигдах шаардлага, ашиглалтын хэвийн нөхцөл найдвартай ажиллагааг хангахгүй болсон тухай/* гарсан, ашиглах

---

<sup>2</sup> Барилгын чанар муудаж доройтохоос өмнө шаардлагатай урсгал засвар, их засварын ажлыг хийх төсөв хөрөнгийг шийдвэрлэж, хүүхдүүдийг эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах

боломжгүй 3 хичээлийн байр 4 дотуур байр байсан. Үүнээс 3 хичээлийн байр, 2 дотуур байрны барилга шинээр баригдаж, 2 дотуур байрны барилгыг их засварт оруулжээ.

№	Сургуулийн нэр	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал	Шинээр баригдах		
				Төсөвт өртөг	Хувь	явц
1	Сайхан-Овоо сумын ЕБС	Хичээлийн байр	320	4,457.0	100%	2022 онд ашиглалтад орсон
2	Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургууль	Хичээлийн байр	640	11,235.0	45%	2024 онд ашиглалтад орно
3	Сайнцагаан сумын ГИЦС	Хичээлийн байр	960	14,726.6	80%	2024 онд ашиглалтад орно
4	Гурвансайхан сумын ЕБС	Дотуур байр	100	1,010.0	100%	2023 онд ашиглалтад орсон
5	Говь-Угтаал сумын ЕБС	Дотуур байр	80	1,569.8	30%	2024 онд ашиглалтад орно
6	Луус сумын ЕБС	Дотуур байр	80	895.3	100%	2023 онд ашиглалтад орсон
7	Адаацаг сумын ЕБС	Спорт зал	-	1,955.1	100%	2024 онд ашиглалтад орно
Нийт дүн				35,848.8		

Аудит хийгдсэнээс хойш шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг тодорхойлж:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан-Овоо сумын ЕБС-ийн хичээлийн байр, Луус сумын ЕБС-ийн дотуур байр, Гурвансайхан сумын ЕБС-ийн дотуур байр, Адаацаг сумны ЕБС-ийн спорт заалыг ашиглалтад оруулсан;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын ГИЦС-ийн хичээлийн байр 80 хувийн, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байр 45 хувийн, Говь-Угтаал сумын ЕБС-ийн дотуур байр 30 хувийн гүйцэтгэлтэй;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ЕБС-ийн 2 хичээлийн байр, 6 дотуур байр, гал тогоо, 1 спорт залны барилгыг их засварт оруулсан байна.

Мөн Азийн хөгжлийн банк, Эрдэнэт үйлдвэр, иргэд, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар сургалт зохион байгуулах материаллаг бааз, сумдын сургуулиудын дотор ариун цэврийн өрөө зэрэг ажлууд хийгдэж хүүхдүүдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг сайжруулсан байна.

*Зөвлөмж №3-ын хүрээнд<sup>3</sup>:*

Сайнцагаан сумын Цэгц билиг, Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумдын сургуулийн барилгын хувийн хэрэгт бүртгэгдсэн суурилагдсан хүчин чадал болон статистик тоо мэдээнд бүртгэгдсэн хүчин чадал хоорондоо зөрүүтэй тусгагдсан нь аймгийн нийт сургуулийн барилгын суурилагдсан хүчин чадлын тоо мэдээ буруу гарах, сургуулиудын ачаалал хэтрэлт бодитой бус байх эрсдэлийг бий болгосон тул зөрчлийг арилгах зөвлөмжийг БШУГ-т хүргүүлжээ.

Цэгц билиг сургуулийн барилга нь зориулалт бус, Цагаандэлгэр сумын сургуулийн барилга нь стандартын дагуу баригдаагүйгээс бодит тогтоосон хүчин чадлаас зөрөх шалтгаан болсон тул зөрүү арилаагүй байна.

<sup>3</sup> Статистик тоо мэдээллийг холбогдох нотлох баримтад үндэслэн бодитой үнэн зөв гаргах



Зөвлөмжийн хүрээнд БШУГ-аас статистик мэдээний үнэн бодит байдлыг “ESIS” мэдээллийн системд сайжруулах ажлыг бүх ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагуудад үүрэг өгч ажилласнаар статистик мэдээний чанарт ахиц гарсан байна. Тухайлбал Статистикийн хэлтсийн хүн ам бүртгэл мэдээллийн сантай тулгалт хийж сургууль завсардсан 6-14 насны 40 хүүхдийг илрүүлэн, насан туршийн боловсролын төвийн боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулжээ.

“ESIS” мэдээллийн системд жил бүр сайжруулалт хийгдэж байгаа тул мэдээлэл давхцах, орхигдох, статистик мэдээ буруу гарах эрсдэл буурсан байна.

*Зөвлөмж №4-ийн хүрээнд<sup>4</sup>:*

ЕБС-иудын 9-р ангийн хүүхдүүдээс 2019 онд математикийн хичээлийн сургалтын чанарт хийсэн БҮТ-ийн чанарын үнэлгээ, БШУГ-ын хөндлөнгийн үнэлгээ, сургуулиас зохион байгуулсан улсын шалгалтын дүнд харьцуулалт хийхэд ихэнх сургуулийн улсын шалгалтын гүйцэтгэлийн хувь, чанарын үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлээс харьцангуй өндөр үзүүлэлттэй байжээ.

Энэ нь улсын шалгалтын даалгавар боловсруулалтыг тухайн сургуулийн багш нар хийдэг мөн бусад шалгалтын даалгавартай харьцуулахад харилцан адилгүй, сурагчдад тухайн шалгалтын даалгаврыг судалж, шалгалтад бэлдэх нөхцөл боломж нээлттэй, шалгалтын материал засалтыг сургуулийн багш нар өөрсдөө хийдэг зэрэг олон шалтгаантай байна.

Харин улсын шалгалтын даалгавар боловсруулалтыг 2019 оноос тухайн сургуулийн багш нар хийхээ больж, БҮТ-ийн улсын шалгалтын даалгаврын сангийн системээс улсын шалгалтын материалыг сонгон авч шалгалтыг авдаг болсон нь шалгалтуудын үнэлгээний зөрүү ойртох нөхцөл бүрдэж байна гэж дүгнэхээр байна.

БҮТ-өөс ЕБС-уудын суралцагчдаас 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд чанарын үнэлгээний шалгалтыг авах байсан боловч улс орон даяар тархсан цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшлуулсан байна.

Харин 2022 оны 10 дугаар сард БҮТ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу Сайнцагаан сумын ЭДЦС, ГИЦС, Эрдэнэдалай сумын ЕБС-ын бага, суурь боловсролын 250 суралцагчдын цогц чадамжийг хэмжих, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна. Гэвч БҮТ-өөс чанарын үнэлгээний дүнг ирүүлээгүй тул харьцуулсан дүгнэлт гаргах боломжгүй байна. Шалгалтуудын үнэлгээний зөрүүг арилгах, боловсролын түвшнийг дээшлүүлэх хүрээнд ЕБС-ийн багш, боловсон хүчний мэдлэг

---

<sup>4</sup> Улсын шалгалтын үнэлгээ болон БҮТ-өөс хийгдэж байгаа чанарын үнэлгээний хоорондын зөрүүг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч, үнэлгээг бодитой хийж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах

боловсролыг дээшлүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Тухайлбал:

2021 оны хичээлийн жилд:

- БШУГ-ын зөвлөн туслах баг Сайнцагаан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өлзийт, Дэрэн, Луус, Дэлгэрцогт сумдын сургуулийн багш нарт зөвлөн туслах үйлчилгээ;
- Нийт 19 сургуулийн багш нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан;
- Дэлгэрхангай суманд баруун бүсийн сумд, Дэрэн суманд Баянжаргалан сумын нийт 115 багш, ажилчдыг хамруулсан туршлага солилцсон;
- Аймгийн хэмжээнд “Чадварлаг багш” хөтөлбөрийг сумдын ЗДТГ-ын даргатай хамтран баталж, нийт сургуулийн 84.2 хувь буюу 15 сургуульд хэрэгжүүлсэн;

2022 оны хичээлийн жилд:

- Боловсролын ерөнхий газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран багшийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллаж 370 орчин багш нарыг сургалтанд бүрэн хамруулсан;
- “Сайн сургууль-Сайн багш” хөтөлбөрийг 2022-11-01 ээс 2022-12-05 ны хооронд аймгийн бүх ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулан үнэлгээний ажлыг зохион байгуулсан;
- МУБИС-тай хамтран бага ангийн багш нарт сургалт зохион байгуулан арга зүйн удирдлагаар хангасан зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

ЕБС-ийн багш, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлснээр боловсролын чанарт хэрхэн ахиц гарсан талаарх харьцуулалтыг сүүлийн 3 улсын шалгалтын дүнг үзвэл:

№	Түвшин	Хичээлийн нэр	Улсын шалгалт			Сүүлийн 2 жилийн ахиц
			2018-2019	2021-2022	2022-2023	
			1	2	3	4=3-2
1	Бага	Математик	52.6	64.8	72.7	7.9
		Монгол хэл	37.4	75.3	78.8	3.5
2	Суурь	Математик	31.9	58.9	68.8	9.9
		Монгол хэл	50.3	70.1	72.1	2.0
		Англи хэл	18.6	63.9	74.9	11.0
3	БДБ	Математик	27.2	70.0	76.4	6.4
		Монгол хэл	49.3	81.4	77.4	(4.0)
		Газарзүй	28.0	74.1	78.8	4.7
<b>Аймгийн дундаж</b>			<b>36.9</b>	<b>69.8</b>	<b>75.0</b>	<b>5.2</b>

Ковид цар тахлаас шалтгаалан 2021 онд улсын шалгалт аваагүй, улсын хэмжээнд сурлагын амжилт, сурагчийн хувийн хэрэг, идэвхийг үндэслэн дүйцүүлэн үнэлж оноог тавьсан байна. Харин 2023 оны улсын шалгалтын дунджийг 2022 онтой харьцуулахад бага, суурь боловсролын математикийн хувьд 7.9-9.9 хувь, монгол хэл 2-3.5 хувиар өссөн байна. Ахлах ангийн хувьд математик 6.4 хувь, газар зүй 4.7 хувиар тус тус өссөн, монгол хэл 4.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 3 улсын шалгалтын дүнг харьцуулан харахад аймгийн дундаж 5.2 хувиар өссөн нь боловсролын чанар сайжирсныг харуулж байна.

**1.2 Аудитын үр дүнд хуульд<sup>5</sup> заасны дагуу шаардлагатай зардлын төсвийг батлуулж байх тухай санал нэгтгэсэн тайланд орж, зөвлөмжийг Сангийн сайдад хүргүүлжээ.**

УТХО-аар гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтыг БШУЯ сургуулийн биет төлөөлөгч бус хүнээр дамжуулж хүргүүлсэн, холбогдох албан тушаалтан нь эд хөрөнгийн жагсаалт, бүртгэлд тусгахад шаардлагатай анхан шатны баримт болон бусад нотлох баримтыг гаргуулж аваагүй зэргээс хөрөнгө дутуу бүртгэсэн зөрчил илэрчээ. Иймд хөрөнгийг хүргүүлэхдээ сургуулийн биет төлөөлөгчөөр дамжуулан, хөрөнгийн жагсаалт, холбогдох анхан шатны баримтын хамт хүргүүлж байх талаар саналыг БШУЯ-нд хүргүүлэхээр уламжилсан ч нэгтгэсэн тайланд тусгаагүй байна.

Харин “Багшийн хөгжлийг дэмжих тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай” хуулийн хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв огт батлагдахгүй байна. Иймд “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-д заасны дагуу шаардлагатай зардлын төсвийг батлуулж байх” зөвлөмжийг хүргүүлэх санал нэгтгэсэн тайланд тусгагджээ.

Дээрх саналын хүрээнд гүйцэтгэлийн аудитын нэгтгэсэн тайланд “Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгө аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудын төсөвт батлагдахгүй байгаагаас гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багшийн хөгжлийг дэмжих, багш сурагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах боломжийг хязгаарлаж байна”. Иймд Сангийн сайдад дараах зөвлөмжийг хүргүүлжээ.



**САНГИЙН ЯАМ**

***Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн төсвийн саналыг нэгтгэн боловсруулахдаа Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, урсгал зардлыг нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн төлөвлөж, хуваарилах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төрөөс баримтлах хөтөлбөр, боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан, тэргүүлэх ач холбогдол бүхий хуулийн шаардлага хангасан байдлаар төлөвлөж, санхүүжүүлэх;***

Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад орон нутгийн боловсролын байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд “Цахим төсвийн төслийн программ”-ыг ашиглаж эхэлснээс эхлэн хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардлын төсвийг төлөвлөж, тусгасан байна. Тус онд хөдөлмөрийн аюулгүй байдлын зардалд 239.7 сая төгрөг, багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардалд 567.4 сая төгрөгийг тус тус төлөвлөж, хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй, зөвлөмж хэрэгжээгүй байна.

<sup>5</sup> Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль



## БҮЛЭГ 2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулжээ.

### 2.1 Шалгагдагч байгууллагууд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилоогүй, төлөвлөгөө гаргаагүй ч зохион байгуулсан ажлууд үр дүнтэй байна.

Аудитаар аймгийн Засаг даргад 2, БШУГ-т 2 зөвлөмж, нийт 4 зөвлөмжийг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүргүүлж, хэрэгжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхээр заажээ. Шалгагдагч байгууллагууд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг тусгайлан томилоогүй, ажлын төлөвлөгөө гаргаагүй байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг БШУГ-ын судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй арга зүйн зөвлөл хариуцан ажиллаж, Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/1681 дугаар албан бичгээр хугацаанд нь ирүүлсэн байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Дундговь аймгийн ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023), Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн Хөгжлийн Банктай хамтран “Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”, Чадварлаг багш хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтүүдийг ханган тодорхой үр дүнд хүрчээ. Чадварлаг багш хөтөлбөрийг “Сайн хичээл аймгийн зөвлөгөөн”, “Эрдэм шинжилгээний хурал”, “Аймгийн бүтээлийн сан баяжуулалт”, “Тэргүүлэх багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэлт” гэсэн 4 чиглэлээр 15 суманд хэрэгжүүлжээ.

Мөн зөвлөмжийн дагуу аймгийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга, хэмжээнүүдийн хүрээнд Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг баталсан байна. Дээрх тогтоолын 4 дүгээр бүлгийн Зорилт 4-т */Дундговь аймгийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын боловсролын чанарыг сайжруулна/* 3 хөтөлбөр, 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийг 300.0 сая төгрөгөөр баталснаас 36.7 хувийг албан хаагчдын нийгмийн баталгаа, урамшуулалд, 30.0 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад, 5.0 хувийг гадаад дотоод туршлага солилцоход, 28.3 хувийг элсэлтийн ерөнхий шалгалтад хамгийн өндөр оноо авсан сурагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр албан хаагчдын нийгмийн баталгаа, урамшуулалд 109.9 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 81.5 сая төгрөг, гадаад дотоод туршлага солилцоход 7.2 сая төгрөг, элсэлтийн ерөнхий шалгалтад хамгийн өндөр оноо авсан 21 сурагчид 12.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын А/01 дүгээр захирамжаар 2023 оныг “Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил” болгон зарлаж 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан баталжээ. Үүнд:

- Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 7 арга хэмжээ
- Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сургалтын амжилтыг ахиулах чиглэлээр 6 арга хэмжээ
- Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 7 арга хэмжээ
- Иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 7 арга хэмжээ
- Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр 11 арга хэмжээ

Арга хэмжээнүүдийг улсын төсвөөс 284.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 487.6 сая төгрөг, нийт 772.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын байдлаар тайлагнан ХШҮХ-ээр хянуулж, 72.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгджээ.



"Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил"-ийн хүрээнд “Багш нарыг багаар нь урамшуулах” удирдамжийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргаж, болзол хангасан 40 багшид 109.9 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

2022-2023 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад нийт шалгуулагчид өмнөх жилийн дундаж оноогоо математик 9.1 оноо, монгол хэл 3.3 оноо, нийгмийн ухаан 8.2 оноо, хими 14 оноо, биологи 4.3 оноогоор тус тус ахиулж, физикийн хичээлээр өмнөх жилийн амжилтаа хадгалж, 6 судлагдахуун дундаж оноогоороо улсын хэмжээнд 1-10 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна.



## Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжилтийг ханган ажилласан байна.
- Хүүхдүүдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг сайжруулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 сургуулийн хичээлийн байр, 2 сургуулийн дотуур байрны барилгыг бариулж байгаагаас 2 барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авчээ.
- Боловсролын яамны “ESIS” мэдээллийн системд жил бүр сайжруулалт хийгдсэнээр мэдээлэл давхцах, орхигдох, статистик мэдээ буруу гарах эрсдэл багассан байна.
- БҮТ-ийн улсын шалгалтын даалгаврын сангийн системээс улсын шалгалтын материалыг сонгон авч шалгалт авдаг болсон нь шалгалтуудын үнэлгээний зөрүү ойртох нөхцөлийг бүрдүүлжээ.
- Аудитын үр дүнд Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-д заасны дагуу шаардлагатай зардлын төсвийг батлуулж байх тухай хүргүүлсэн санал нэгтгэсэн тайланд орж, Сангийн сайдад зөвлөмж хүргүүлжээ.
- Гүйцэтгэлийн аудитын дүнд боловсролын байгууллагуудын талаар баримтлах бодлого сайжирч, аймгийн хэмжээнд 5 төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс 279.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг  
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39  
E-mail: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn) ОН